

НОГООН ЭДИЙН ЗАСАГ, ТОГТВОРТОЙ ҮЙЛДВЭРЛЭЛ БА ХУДАЛДАА



3-р хэсэг: Хөдөө аж ахуйн тогтвортой
үйлдвэрлэл, өртгийн сүлжээ ба худалдаа


5-р сарын 29-30, Улаанбаатар хот, Монгол Улс

Тогтвортой худалдан авалтын гол хөдөлгөгчүүд



Европийн Холбооны Зах Зээлийн Чиг Хандлага


- ЕХ-ны нийт оршин суугчдын 26% нь **ихэвчлэн** байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн худалдан авдаг ба 54% нь **заримдаа** худалдан авдаг гэсэн байна. (Eurobarometer 367, 2013)
- Байгаль орчны нөлөөлөл нь ЕХ-ны хэрэглэгчдийн хувьд чанар болон үнэ гэсэн хүчин зүйлийн дараагаар 3-рт ордог (Eurobarometers 2009, 2013)
- Ногоон худалдан авалт нь эрчимтэй өссөөр байгаа ба ЕХ-ны хууль тогтоомжинд эрх баригчдыг олон нийттэй гэрээ байгуулахаас өмнө байгаль орчны шалгуур тавихыг зөвшөөрдөг байна.
- Доорх графикийн үр дүнгээс харахад судалгаанд оролцогчид сарын боломжит төсвийнхөө ¼ -тай тэнцэх эсвэл илүү хэмжээний мөнгийг ногоон бүтээгдэхүүний худалдан авалтанд нэмж зарцуулахад бэлэн байна гэж хариулжээ.



Их Британи Улсын Зах Зээлийн Чиг Хандлага

- 2015 онд Их Британи Улсын Ногоон хэрэглээний зах зээл нь £ 38 тэрбумаар хэмжигдэж байсан.
- Мөн энэ салбарын борлуулалт нь **8.5%**-иар өсч, 13 жил дараалан өссөн гэсэн үзүүлэлттэй гарсан.
- Тогтвортой Загасны худалдаа хурдацтайгаар өссөн ба цаашдаа улам илүү өсөх хандлагатай байна.
- Ногоон хэрэглээний хоол, ундааны зах зээлийн хамгийн том хэсгийг органик бүтээгдэхүүн эзэлж байгаа ба одоогоор Их Британи Улсын хоол, ундны нийт зах зээлийн 1.4%-ийг эзэлж байна.

Ethical spending in the UK, 1999-2015




Эх үүсвэр: Ethical consumer markets report 2016 UK



LABOUR IMPACT
FOR GOOD

Органик бүтээгдэхүүн Дэлхийн зах зээлд


Дэлхийн Органик бүтээгдэхүүний борлуулалт, 2014 онд



Эх үүсвэр: *ifoam-eu*

Органик бүтээгдэхүүн Дэлхийн зах зээлд

Дэлхийн Органик бүтээгдэхүүний зах зээл (улсаар)




Эх үүсвэр: FiBL

Европын органик зах зээл

- 2014 онд Европын органик бүтээгдэхүүний зах зээл 7.4%-иар өсч € 24 тэрбумд хүрсэн
- Органик зах зээлийн талаар мэдээлэл өгсөн бүх улс орнуудын органик зах зээлийн хэмжээ нь эерэг өсөлттэй байсан.
- Герман улс (€7.9 тэрбум) нь ЕХ-нд хамгийн том органик зах зээлтэй хэвээр байгаа төдийгүй дэлхийд АНУ-ын дараагаар 2-рт явж байна.
- ЕХ-нд 1700 орчим органик хүнсэн бүтээгдэхүүн импортлогчид байгаа ба тэдний хамгийн олон нь буюу 326 нь Герман Улсад байна.

Европын органик зах зээл


Европ Тивийн органик бүтээгдэхүүний худалдаа, 2014 онд



Эх үүсвэр: *ifoam-eu*

Европын органик зах зээл

Европын органик худалдааны өсөлт, 2005-2014 онуудад



Европын органик зах зээл

Герман Улсын органик худалдаа, бүтээгдэхүүний төрлөөр
2014 онд



Хятад Улсын органик зах зээл

- Хятад Улсын органик бүтээгдэхүүний импортын үнэ болон багтаамжийн мэдээлэл нь мэдэгдэхгүй байгаа бөгөөд ойролцоогоор \$20 сая орчим гэсэн таамаглал байгаа ба үүний тал нь үйлвэрлэлд ашиглагддаг органик түүхий эд, үлдсэн нь дотоодын хэрэгцээнд ашиглагддаг гэж үзэж байна. Хятад Улсын ихэнх импортын органик бүтээгдэхүүнийг АНУ, Австрали болон ЕХ-ноос нийлүүлж байна.
- Голлох импортын органик бүтээгдэхүүнд органик сахар, хатаасан жимс, шинэ жимс, самар, халуун ногоо, кофе, зөгийн бал болон амуу тариа зэрэг ордог.
- Экспортлогчдын хувьд байж болох боломжууд нь боловсруулсан бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт бэлдмэл, хүүхдийн хоол, сүүн бүтээгдэхүүн, болон тансаг хоол, вино зэрэг байна.

Япон Улсын органик зах зээл

- Япончууд нь байгаль орчин болон тогтвортой орчины талаар сайн мэдээлэлтэй бөгөөд хүрээлэн буй орчин болон нийгмийн хариуцлагыг тэдний суурь зарчим нь гэж үзэж болно.
- Японы хэрэглэгчид нь байгаль орчны болон нийгмийн ямар асуудлуудтай нүүр тулгардгийг ойлгох явдал нь үйлдвэрүүдийг тус хөгжингүй оронтой илүү ойлголцож, харилцах боломжийг нээх ба хүнсний аюулгүй байдал, дэлхийн дулаарал, усны нөөц зэргээс гадны хараат байдал нь тэдний хувьд том асуудал байдаг.
- Хэдийгээр Япончуудын эрүүл хооллох хандлага нь нэмэгдэж байгаа ч генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүн болон хүнсний аюулгүй байдлын асуудал хурцаар яригдаж байгаа.
- Япончууд нь байгаль орчноо гэсэн зан чанарыг өндөр үзүүлдэг.
- Япончууд нь аль байгууллага нь хэрхэн үйл ажиллагаа явуулж байгаа, тухайн үйл ажиллагаа нь нийгэм болон байгаль орчиндоо хэрхэн нөлөөлж байгааг цаг тутам хянаж байдаг ба нээлттэй, нийгмийн хариуцлагатай байх нь маш чухал ач холбогдолтой.